



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/405

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Биеийн тамир спорт хороонд шаардлагатай хэрэглэл материалыг нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Санаа мед трейд” ХХК-тай 49 392 000 (дөчин есөн сая гурван зуун ерэн хоёр мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Биеийн тамир, спортын газар (Х.Батхишиг)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авч, данс бүртгэлд тусгахыг Биеийн тамир, спортын газар (Х.Батхишиг)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Санаа мед трейд” ХХК-ийн захирал (А.Батцэнгэл)-д даалгасугай.

4.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010378

Аймгийн Засаг даргын 2023 оны  
05 дугаар сарын 23 ны өдрийн  
А/Хуульч дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Тайлбар	Хариуцах албан тушаалтан
1	Бараа нийлүүлсний дараах чанарын болон баталгаат засварын хугацаа	1 жил	Х.Батхишиг
2	Алданги	Хоногт 0.1 хувь байна.	Д.Батцогт